



Үндэсний аудитын газрын харьяа
Хэнтий аймгийн аудитын газар

**БАЙГАЛЬ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДЛЫГ
ХУУЛЬД ЗААСАН ХЭМЖЭЭГЭЭР БАТЛАХГҮЙ БАЙНА.**

Аудитын нэр: ***“Байгаль орчныг хамгаалах
тухай хуулийн хэрэгжилт”***

Аудитын код:
УАГ-НАГ/2016/05-НА-ХЭ



10/10/2016

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн Хэнтий аймгийн Аудитын газар	Агуулга	
	Тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин	Товчилсон үгийн тайлбар
	Аудитын менежер: Б.Наранцэцэг	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл
	Ахлах Аудитор: Н.Туяа	Ерөнхий мэдээлэл
	Шинжээч: Д.Эрдэнэбилэг	Нэгдүгээр бүлэг: Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга хуульд заасан үүргээ хангалтгүй биелүүлж байна.
		Хоёрдугаар бүлэг: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлгүй бууруулан төлөвлөж байна.
		Гуравдугаар бүлэг: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасны дагуу хөрөнгө хуваарилахгүй байна.
		Дөрөвдүгээр бүлэг: Байгаль хамгаалах хуулийн хэрэгжилтэд хийх хяналт, шалгалтын зардал дутмаг байна.
	2016 оны 09 дугаар сар	Аудитын дүгнэлт
	Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147 тоот утсаар харилцана уу.	Аудитын зөвлөмж
Хаяг Хэнтий аймгийн Аудитын газар. Аймгийн ЗДТГ-ын байр. 325 тоот өрөө		Үндэсний Аудитын газарт хүргүүлэх санал
		Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн холбогдох байгууллагын санал
		Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд өгөх тайлбар
		Аудитаар илэрсэн зөрчил ба акт, албан шаардлагын жагсаалт
		Аудитын тайлангийн баталгаажуулалт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ХБХ	Хөгжлийн Бодлогын Хэлтэс
СТСХ	Санхүү Төрийн Сангийн Хэлтэс
СЯ	Сангийн Яам
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БХНСЗ	Байгаль Хамгаалах Нөхөн Сэргээх Зардал
НАТО	Нөөц Ашигласны Төлбөрийн Орлого
ТАХ	Төсөл Арга Хэмжээ
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
БНГ	Байгалын Нөөц Газар
ТХГ	Тусгай Хамгаалалттай Газар
БХС	Байгаль Хамгаалах Сан

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Нэг: Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2016 оны 1 дүгээр тогтоол, Монгол улсын Ерөнхий Аудитортой аймгийн Тэргүүлэх аудиторын 2016 онд байгуулсан үр дүнгийн гэрээ, Хэнтий аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, Монгол улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт бүрэн эрх”-ийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Хоёр: Аудитын зорилт

“Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”-д хийж буй нийцлийн аудитын хүрээнд Хэнтий аймагт байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг хэрхэн зохион байгуулсан, байгаль хамгаалах салбарт мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа эсэхийг шалгаж дүгнэлт, зөвлөмж гарган аудитын дүнг аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулан аудитын тайланг ҮАГ-т хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитыг дараах зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- *Аймаг, сумын ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргээ биелүүлсэн эсэх,*
- *Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх,*
- *Байгалийн НАТО-оос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх,*
- *Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх,*

Гурав: Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Галшар, Бор-Өндөр, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Батширээт, Биндэр, Дадал, Норовлин, Батноров сумдын ЗДТГ-ыг хамруулан тэдгээрийн Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлын тайлан, мэдээ, судалгаа, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, зарцуулалтын баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Дөрөв: Аудитын арга зүй, стандартын талаах мэдээлэл

Аудитад АДБОУС 100-400, 4200, нийцлийн аудитын гарын авлагыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, зураг авах зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Тав: Аудит хийсэн хугацаа:

Аудитын төлөвлөх үе шатны ажлыг 2016 оны 8 дугаар сарын 28-аас 31-ний хооронд хийж, гүйцэтгэх үе шатны ажлыг 9 дугаар сарын 1-ээс 23-ны хооронд, тайлагнах үе шатны ажлыг 9 сарын 26-аас 30-ны хооронд хийж холбогдох байгууллагаас саналыг авч, аудитын дүн, тайланг аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлд 2016 оны 10 дүгээр сарын 10-нд шинжээч Д.Эрдэнэбилэг танилцуулна.

Долоо: Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин удирдаж, аудитын менежер Б.Наранцэцэг аудитын үйл явцад хяналт тавьж, ахлах аудитор Н.Туяа аудитыг зохион байгуулж, шинжээч Д.Эрдэнэбилэг хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 3.1 “Энэ хуулиар байгалийн ургамал, ус, ой, ан амьтны нөөцийг ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг зохицуулна” гэж заасан байна.

Монгол улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.1 “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах, төсвийн орлогыг “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаар болон дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.” гэж заажээ.

Аймгийн хэмжээнд 18 сумын хэмжээнд 35 байгаль хамгаалагч, 18 байгаль орчны хяналтын улсын байцаагч нар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон сумдын байгаль хамгаалах санд нийтдээ 1196,3 сая төгрөг төвлөрч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ болон байгаль хамгаалах ажилд 351,2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үүнээс аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор 1299.9 сая төгрөг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1096,8 сая төгрөгийн орлого төвлөрч орлогын төлөвлөгөө 203,1 сая төгрөгөөр тасарсан байна.

Харин сумдын “Байгаль хамгаалах сан”-д 2015 онд 99,5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 115,6 сая төгрөгийг зарцуулсан байна.

2015 онд аймгийн хэмжээнд байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар 235,6 сая төгрөгийн 44 ажил хийгдсэн ба төлөвлөгдсөн ажлуудаас 67,5 сая төгрөгийн 4 ажил 2016 онд шилжин хийгдэхээр болсон байна.

**НЭГДҮГЭЭР
БҮЛЭГ**

**•АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ
ДАРГА ХУУЛЬД ЗААСАН ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ БИЕЛҮҮЛЖ
БАЙНА.**

1.1. Аймгийн ИТХ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлж байгаа боловч сумдын ИТХ энэ үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна

Хэнтий аймгийн ИТХ нь 2015 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ түүнд шаардагдах төсөв хөрөнгийг баталсан нь “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 16.1.1-тэй нийцэж байна.

Аймгийн ИТХ 2015 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор 1299,9 сая төгрөг оруулахаар төлөвлөн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд 329,5 сая төгрөгөөр 48 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Гэсэн хэдий ч аймгийн ИТХ нь 2015 оны төсвийг батлаж “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого”-оос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд зарцуулах хувийг тооцохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалтыг мөрдөөгүй нь мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т¹ заасан хариуцлага хүлээлгэх нөхцөл үүсч байгаа тул хуулийг мөрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Харин Төрийн сан банкинд байршиж байсан аймгийн “Байгаль хамгаалах сан”-ийн данс 2014 онд хаагдан 2015 оны 01 сараас БОАЖГ-ын төсөвт “Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал” нэрээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өөрчлөн тусгаж хэрэгжүүлж байна.

Харин сумдын ИТХ нь сумын төсвийн орлогод хамаарах ой, ан зэрэг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг баталж байгаа боловч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ болон түүнд шаардагдах зардлыг батлаагүй нь “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 17.1.1²-т заасан эрхийг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тооцох боломжгүй болгож байна.

Аймгийн нийт 17 сумдад “Байгаль хамгаалах сан”-д нөхөн сэргээлтийн барьцаа, торгуулийн орлогоос өөр орлого ордоггүй, санд орсон орлогыг сумын ИТХурлаар баталдаггүй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөдөггүйгээс орлогын ихэнх хэсэг нь хяналт шалгалтын шатахууны зардалд зарцуулагддаг байна.

Сумдын “Байгаль хамгаалах сан”-гийн үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 2012 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах сангийн зохион байгуулалт”-аар зохицуулагдан ажиллаж байна.

Хэнтий аймгийн 17 суманд байгаа байгаль хамгаалах санд орсон орлого болон зардлын гүйцэтгэлийг судлан үзэхэд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.1, 12.2 дахь заалтууд хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна.

¹ 25.2.Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувь, хэмжээг бууруулсан, төлбөрийн орлогын хэсгийг өөр зориулалтаар ашигласан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлнэ.

² Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүнийг баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавина.

1.2. Сумдын байгаль хамгаалагч, улсын байцаагчдын шаардлагатай техник хэрэгсэл, хувцсаар хангах ажил дутагдалтай байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар 2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор бүрдэх төсвийг Сангийн яаманд хянуулсан дүнгээс 323,3 сая төгрөгөөр өсгөн 1164,7 сая төгрөгөөр батлуулсан байна.

2015 оны Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогийн бүрдүүлэлтэд 1 аргал, 20 зэрлэг гайхай, 5 бор гөрөөс агнах бол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 765,3 мянган м3 усны нөөцийг ашиглах, ойгоос үйлдвэрлэлийн болон арчилгааны огтлолт, ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд 42133,2 м3 модыг ойгоос бэлтгэж ашиглахаар төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг дарга нь “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5³ дах заалтыг хэрэгжүүлээгүйгээс байгаль орчны улсын байцаагчдын хувцас, техник хэрэгслийн хангалтыг хийгээгүй бол мөн хуульд заасны дагуу байгаль хамгаалагч нарыг хувцасаар хангасан байна.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 01 тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд батлагдсан хөрөнгөөр 2015 онд 18 сумдын 35 байгаль хамгаалагч, аймгийн БОАЖГ-ын 9 ажилтан, аймгийн ХБХ-ийн даргад 1, нийт 45 ажилтны өвөл, зуны хувцас, гутлыг 17,7 сая төгрөгөөр авч аймгийн БОАЖГ-ын эд хөрөнгөд бүртгэн хангалтаар сумдад олгосон боловч тус хуулинд хамаарахгүй ажилтанд хангалтаар өгсөн хувцсыг буцааж авах шаардлагатай байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн даргаар ажиллаж байсан Д.Эрдэнэбаатар нь эрх мэдлээ ашиглан байгаль хамгаалагчийн өвлийн хувцаснаас нэгийг авсан боловч өнөөдрийг хүртэл буцааж өгөөгүй байна.

Аймгийн хэмжээний байгаль хамгаалагчдын хувцас хэрэгсэл, техник хэрэгслийн судалгаанаас харахад байгаль хамгаалагчдад өвөл, зуны хувцас, хавар намрын гуталны хангалт хийсэн бол 17 байгаль хамгаалагчид мотоцикльтэй боловч 3 мотоцикль нь албан ажлаа явуулахад хэвийн ажилладаг, 14 мотоцикль нь чанарын шаардлага хангахгүй, явдаггүй, ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь тус ажилтнууд байгаль хамгаалах ажлаа гүйцэтгэх боломж муу, бие хамгаалах багажгүй зэрэг нь эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа гэж үзэхээр байна.

Зарим сумдын ЗДТГ нь сумын байгаль хамгаалагч нартаа зарим хангалтыг хийж өгсөн байна.

2015 онд Жаргалтхаан, Батноров, Дадал, Хэрлэн сум байгаль хамгаалагчиддаа мотоцикль авч өгсөн бол Дэлгэрхаан сум 2 мотоцикль, зөөврийн компьютер, 2 дуран, 2 GPS зэргээр хангасан байна.

Сумдад байгалийн нөөц ашигласнаас орлого орж байгаа боловч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг сумдад баталдаггүй, уг ажлыг аймгийн ИТХ гүйцэтгэдэг нь сумдыг байгаль хамгаалах ажлыг төлөвлөхөд хүндрэл учирч байгаа хэдий ч энэ ажлыг огт хийгээгүй байгаа нь “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулинд⁴ заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй нь байгаль хамгаалагчдыг шаардлагатай техник хэрэгсэл, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсгээр хангах бүрэн эрхээ хангалтгүй биелүүлж байгааг харуулж байна.

³ 5/ нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах;

⁴ 17.1.1 “Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих,

**ХОЁРДУГААР
БҮЛЭГ**

**•БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ
ҮНДЭСЛЭЛГҮЙ БУУРУУЛАН ТӨЛӨВЛӨЖ БАЙНА.**

2.1. Аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Хэнтий аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас аймгийн 2015 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө 2014 оны газар, ус, ангийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлээс 11,1-53,1%-иар бууруулан тооцсон бол ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2,1 дахин нэмэгдүүлж орлогыг нийт дүнгээр 106%-иар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

/сая.төг/

д/д	Орлогын төрөл	2014 оны гүйцэтгэл	2015 оны БОАЖГ-ын төлөвлөгөө	Өсөлт/бууралт
1	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	174,0	364,3	+209,3%
2	Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	600,8	534,4	-11,1%
3	Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	84,2	39,5	-53,1%
4	Газрын төлбөр	126,2	106,2	-15,8%
	Бүгд	985,3	1044,5	+106%

Монгол улсын Засгийн газрын 2014 оны 307 дугаар тогтоолоор ойгоос ашигласан модны төлбөрийн хэмжээ 2,2 дахин өсгөсөн тул 2015 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 2 дахин нэмэгдүүлэн төлөвлөхөд хүргэсэн байна.

Иймд аймгийн БОАЖГ-аас боловсруулж хүргүүлсэн 2015 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэлтийн хүрээнд 2014 онд ойгоос ашигласан 56524 м3 модны хэмжээг 2015 онд 14,4 мян м3-ээр бууруулан 42133,2 м3 болгон аймгийн СТСХэлтэс үндэслэлгүйгээр бууруулан, Сангийн яаманд 846,2 сая төгрөгөөр төлөвлөж, хүргүүлэн батлуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 12 сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2015 оны байгалийн нөөц ашигласны орлогыг батлахдаа Сангийн яамны хянасан дүнгээс усны орлогыг 5,0 сая төгрөгөөр бууруулсан бол ойн орлогыг 188,8 сая төгрөгөөр, ангийн орлогыг 25,4 сая төгрөгөөр, ус, рашаан ашигласны орлогыг 104,4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийтдээ 318,6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийтдээ 1164,7 сая төгрөгөөр батлуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 2 сарын 9-ны XIV хуралдааны 01 тогтоолоор байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тодотгохдоо ус, рашаан ашигласны болон газрын төлбөрийг орлогыг өөрчлөөгүй бол ойн нөөц ашигласны орлогыг 55,5 сая төгрөгөөр бууруулж, ан амьтны нөөц ашигласны орлогыг 190,7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт дүнгээр 135,2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1299,9 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ЗДТГ-т байгаль хамгаалах сан байхгүй боловч сумдад ашиглагдаж байгаа “Байгаль хамгаалах сан”-г “Төсвийн тухай хууль”-д нийцүүлэн үйл ажиллагааг нь зогсоох чиглэлийг Сангийн сайдын 2016 оны 4-3/760⁵ тоотойр аймгийн ЗДТГ-т ирүүлсэн байна.

Харин аймгийн хэмжээний 17 сумдад үйл ажиллагаа явуулж байгаа “Байгаль хамгаалах сан”-д орох орлого тодорхойгүй, тогтвортой бус учир төлөвлөх боломжгүйгээс сумын төсөвт тус орлогыг төлөвлөдөггүй байна.

2.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого бүрэн төвлөрөөгүй байна.

Хэнтий аймгийн 2015 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого жилийн эцсийн гүйцэтгэлээр 1096,8 сая төгрөг төвлөрсөн боловч орлогыг бодитой бус нэмэгдүүлэн баталж байсны дүнд жилийн эцсийн байдлаар 203,1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна.

2015 он, сая төг

д/д	Орлогын төрөл	БОАЖГ-ын төлөвлөсөн	СЯ-ны хянасан	Аймгийн ИТХ-ын баталсан	Аймгийн ИТХ-ын тодотгосон	Гүйцэтгэл
1	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	165,1	166,0	354,8	299,3	252,6
2	Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	534,4	534,4	638,8	638,8	408,0
3	Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	39,5	39,5	64,9	255,6	269,8
4	Газрын төлбөр	106,2	106,2	106,2	106,2	166,3
	Бүгд	845,2	846,2	1164,7	1299,9	1096,8

Харин сумдын “Байгаль хамгаалах сан”-д 2015 онд 99,5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 115,6 сая төгрөгийг зарцуулсан боловч орлого болон байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлыг сумын төсөвт тусган батлуулаагүй байна.

Аймгийн БОАЖГ-ын боловсруулж төлөвлөсөн 2015 оны ой, ус, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын төлбөрийн орлогыг төлөвлөсөн БОАЖГ-ын төлөвлөлт 1044,5 сая төгрөг нь жилийн эцсийн орлогын гүйцэтгэл 1096,8 сая төгрөгтэй харьцуулахад орлого биелэх боломжтойгоор бодитой төлөвлөсөн байсныг харуулж, аймгийн төрийн сан орлогыг үндэслэлгүйгээр бууруулан хянуулсан гэж үзэж байна.

Үүнээс Байгаль хамгаалах сангийн 2015, 2016 оны эхний хагас жилийн орлого зарлагын гүйцэтгэлийг Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Норовлин, Дадал, Батноров, Дархан, Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Бор-Өндөр, Жаргалтхаан, Галшар, Хэрлэн сумдад очиж газар дээр нь ажиллалаа. Байгаль хамгаалах санд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7.1, 12.1⁶-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан боловч сумын байгаль хамгаалах санд хуулийн дагуу орлого бүрэн төвлөрдөггүй дараах байдалтай байна.

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуульд заасны дагуу “Сумын байгаль хамгаалах сан”-д орлого төвлөрүүлж байгаа сумд байна.

⁵ Орон нутаг нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон бусад салбарын хууль, мөн Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын хүрээнд тусгай сантай байх, бусад санг татан буулгах ажлыг зохион байгуулах,

⁶ Байгаль хамгаалах сангийн хөрөнгө дараахи эх үүсвэрээс бүрдэнэ. /12.1.1-12.1.6/

Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг Батширээт сум 500.0 мянган төгрөг, Норовлин сум 26750.0 мянган төгрөг, Батноров суманд өнгөт чулууны торгуульд 5042.6 мянган төгрөг, Өмнөдэлгэр суманд хохирлын төлбөрт 3314.3 мянган төгрөг, Жаргалтхаан сум хандивын орлогод 1250.0 мянган төгрөг, Цэнхэрмандал суманд хохирлын төлбөрт 1520.0 мянган төгрөг зэргийг сумын байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн байна.

Сумдын “Байгаль хамгаалах сан”-д иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого, модны гоожингийн хураамж, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө, торгууль зэргээс бүрдэж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй, орлогыг үндэслэлтэй төлөвлөх нөхцөл бүрдээгүй харуулж байна.

Харин Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж, Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого, Ус бохирдуулсны төлбөрийн орлого, Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлогууд төсөвт төвлөрч байна.

Мөн тус санд хамааралгүй, орон нутгийн төсөвт төвлөрөх орлогыг санд төвлөрүүлсэн тохиолдол сумдад гарч байна.

Норовлин сум БОАЖЯамнаас шилжүүлсэн чонын төлбөр 6243.2 мянган төгрөг, Баян-Адрага, Жаогалтхаан сумд нохойн татварт 540,5 мянган төгрөг, Цэнхэрмандал сум Сум хөгжүүлэх сан хаагдаж өвсний орлого 1200.0 мянган төгрөг, Дэлгэрхаан сум шонхор шувууны орлого 6400.0 мянган төгрөг зэрэг 14383,7 сая төгрөгийн санд орохгүй орлогыг бүрдүүлсэн байна

Дээрх аудитаар ажилласан сумдын байгаль хамгаалах сангийн 2015 оны эхний үлдэгдэл 86927.6 мянган төгрөг байсан бол оны эцэст 80074.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

•БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ХӨРӨНГӨ ХУВИАРЛАХГҮЙ БАЙНА.

3.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлыг хуулийн дагуу тооцож хуваарилаагүй байна.

Хэнтий аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас төлөвлөсөн 2015 оны байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг Сангийн яам хянахдаа “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн⁷ дагуу тооцож хянасан байна.

Харин аймгийн ИТХ-ын 2014 оны 12 сарын 3-ны 01 дүгээр тогтоолоор БХНСЗ-ыг батлахдаа газрын төлбөрийн орлогоос байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувийг хуулийн дагуу тооцсон бол ойн нөөц ашигласны орлогоос БХНСЗ-д тооцох хувийг 39,8%-иар, ус рашаан ашигласны төлбөрийн орлогоос БХНСЗ-д

⁷ 18.1 “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалын баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: “Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогийн 85%, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогийн 35%, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогийн 50%, газрын төлбөрийн орлогийн 15%-ийг БОХНСЗ-д зарцуулна,

тооцох хувийг 23,9%-иар, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос БХНС3-д тооцох хувийг 30,4%-иар тооцож дээрхи хуулийн заалтыг мөрдөөгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 2 сарын 9-ний XIV хуралдааны 01 дүгээр тогтоолоор байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тодотгон өөрчлөхдөө газрын төлбөрийн орлогоос БХНС3-д зарцуулах санхүүжилтийг хэвээр үлдээсэн бол ойн нөөц ашигласны орлогоос БХНС3-д тооцох хувь 47,1%, ус рашаан ашигласны төлбөрийн орлогоос БХНС3-д тооцох хувийг 23,9%, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос БХНС3-д тооцох хувийг 7,7% болж өөрчлөгдсөн боловч хуульд заасан хувьд хүрэхгүй байна.

2015 оны байгалын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт

/сая.төг/

д/д	Орлогын төрөл	Хуваарилагдсан зардал	Орлогын төлөвлөлт			
			Анх батлагдсан		Тодотгосон	
			Аймгийн ИТХ-ын баталсан орлого	БОХНС-д хуваарилсан санхүүжилтийн хувь	Аймгийн ИТХ-ын баталсан орлого	БОХНС-д хуваарилсан санхүүжилтийн хувь
1	Ойн НАТО	141,1	354,8	39,8	299,3	47,1
2	Ус, рашааны НАТО	152,7	638,8	23,9	638,8	23,9
3	Амьтны НАТО	19,7	64,9	30,4	255,6	7,7
4	Газрын төлбөр	15,9	106,2	15,0	106,2	15,9
	ДҮН	329,4	1164,7		1299,9	

Ийнхүү 2015 онд тодотгосон Хэнтий аймгийн 2015 оны байгалийн нөөц ашигласны орлогын төрлөөс ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос БХНС3-д зарцуулах зардлыг хуульд заасан хувиар тооцож мөрдсөн бол бусад байгалийн НАТО-оос БХНС3-д зарцуулах зардлыг хуулийн дагуу тооцоогүйгээс байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлыг 292,3 сая төгрөгөөр дутуу баталж “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна.

2015 онд Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг тооцсон байдал

/сая.төг/

д/д	Орлогын төрөл	Аймгийн ИТХ-р батлагдсан орлого	Аймгийн ИТХ-р батлагдсан зардал	Хуулиар тооцвол зохих зардал	зөрүү
1	Ойн НАТО	299,3	141,1	254,4	-113,3
2	Ус, рашааны НАТО	638,8	152,7	223,6	-70,9
3	Амьтны НАТО	255,6	19,7	127,8	-108,1
4	Газрын төлбөр	106,2	15,9	15,9	0,0
	ДҮН	1299,9	329,4	621,7	292,3

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 2015 онд аймгийн ИТХ-аас 48 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 67,5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг 2016 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан бол үлдсэн 44 төсөл, арга хэмжээг 2015 онд хэрэгжүүлсэн байна.

Тус 44 төсөл, арга хэмжээнд 235,4 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн санхүүжүүлсэн бол 4 төсөл, арга хэмжээний 26,6 сая төгрөгийн ажлын санхүүжилтийг 2016 онд хийгдэх ажилд тусган санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

2015 онд хэрэгжсэн нийт 44 төсөл, арга хэмжээний биелэлт 90,9%-тай байгаа ба 4 төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

Онон голын сав газарт усны тооллого хийх, Батноров сумын төвд ногоон байгууламж байгуулах, УЦУОШТөвд хүлэмж олгох, Чингис хотын төвд уст цэг барих ажил хангалтгүй хийгдсэн байна.

3.2. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд дутуу баталж байна.

Хэнтий аймагт 2015 онд ойн нөөц ашигласны орлогоор 299,3 сая төгрөг оруулахаар баталсан боловч жилийн эцсийн гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөө 84,4 хувь буюу 252,6 сая төгрөгөөр биелж орлого 46,7 сая төгрөгөөр тасарсан байна.

2015 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл 252,6 сая төгрөгөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг хуулийн 18.1-д зааснаар тооцвол 214.7 сая төгрөгийг ойн нөхөн сэргээлтийн ажилд зарцуулахаар байна.

Гэтэл 2015 онд ойг хамгаалах, нөхөн сэргээх 10 төсөл, арга хэмжээнд нийт 75,9 сая.төг зарцуулсан нь зарцуулбал зохих хөрөнгийн 35,4 %-тай тэнцэж байна. Үлдэх 64,6% буюу 138,8 сая төгрөгийг төсвийн бусад зардалд зарцуулжээ.

Энэхүү зардлаар түймэр унтраах бэлэн байдлын үзлэг, ойжуулалт, хилийн бүст харлуулсан зурвас татах, ногоон байгууламж зэргийг хийж гүйцэтгэсэн нь ЗГ-ын 2014 оны 43-р тогтоолын 3,3-т заасан арга хэмжээнүүдтэй нийцэж байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.3-тэй нийцэж байна.

Гэвч зарим ажлыг хийж гүйцэтгэхэд тавигдах тусгай шаардлага болон гүйцэтгэгч байхгүй гэсэн шалтгаанаар шууд гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн байна.

- *Хилийн зурваст түймрээс хамгаалах шороон зурвас татах ажлыг хилийн цэргийн 0287-р ангитай шууд гэрээ байгуулан, Хэрлэн голын сав газарт уст цэгийн тооллого зохион байгуулах ажлыг Хэрлэн болон Онон голын сав газрын захиргаадтай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.*
- *Онон голын сав газрын захиргаа нь тооллогын ажлыг зохион байгуулахаар олгосон 16,2 сая төгрөгийг үр ашиг муутай зарцуулж, СТА-аар 3,2 сая төгрөгийн акт тавигдсан байна.*

3.3. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд дутуу хөрөнгө хуваарилаж байна.

2015 онд ус, рашааны нөөц ашигласны орлогоор 638,8 сая төгрөг оруулахаар тооцож баталсан боловч жилийн эцсийн гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөө 63,8 хувь буюу 408,1 сая төгрөгөөр биелж, орлого 230,7 сая төгрөгөөр тасарсан байна.

2015 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл 408,1 сая төгрөгөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг хуулийн 18,1-д

зааснаар тооцвол 142,8 сая төгрөгийг ус, рашааныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар байна.

Гэтэл 2015 онд ус, рашааныг хамгаалах, нөхөн сэргээх 13 төсөл, арга хэмжээнд 84,5 сая төгрөгийг зарцуулсан нь зарцуулбал зохих хөрөнгийн 59,2%-тай тэнцэж байна. Үлдэх 40,8% буюу 58,3 сая төгрөгийг төсвийн бусад зардалд зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд 2015 онд ус рашааны нөөц хамгаалах, нөхөн сэргээх зардлаар үүлэнд нөлөөлж хур оруулах, худаг гаргах, булаг шанд хаших, ундны эрүүл бүс тогтоох зэрэг усны чиглэлийн дараах ажлуудыг ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоор хийж гүйцэтгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.1-тэй нийцэж байна.

Үүнд: байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгдсөн ажилд өөрчлөлт орж 1 ТАНХ-г 2015 оны 12 сард тендерийг зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулан ажлыг 2016 онд гүйцэтгэхээр болж санхүүжилтийн урьдчилгааг олгосон боловч ажил хийгдэж дуусаагүй байна.

Өндөрхаан хотын цэвэр усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажилд 2015 онд төлөвлөсөн зардлаас тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг хэтэрсэн тул “Хэнтий-Ус” ХХК-д 25,0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг 2015 онд санхүүжүүлсэн боловч худаг гаргах ажил дуусаагүй байна.

Харин санхүүжилт хүрэлцээгүйн улмаас ус хангамжийг сайжруулах чиглэлээр хийгдэхээр төлөвлөгдсөн 18,0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг 2016 онд санхүүжүүлэхээр хойшлуулсан байна.

Өмнөдэлгэр, Норовлин, Баянмөнх сумдын төвийн ундны худагт ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурьшуулах ажил 2016 онд хэрэгжихээр болж хойшилжээ.

3.4 Байгалийн ургамал, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд дутуу төлөвлөж байна.

Аймгийн хэмжээнд 2015 онд ан, амьтны нөөц ашигласны орлогоор 255,6 сая төгрөг оруулахаар тооцож батлагдсан боловч жилийн эцсийн гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөө 105,5 хувь буюу 269,8 сая төгрөгөөр биелж орлого 14,2 сая төгрөгөөр давсан байна.

2015 онд байгалийн ургамал, ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл 269,8 сая төгрөгөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хуулийн 18,1-д зааснаар тооцвол 134,9 сая төгрөгийг байгалийн ургамал, ан, амьтныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулахаар байна.

Гэтэл 2015 онд Хэнтий аймгийн байгалын ургамал, ан, амьтныг хамгаалах, нөхөн сэргээх 14 төсөл, арга хэмжээнд 12,4 сая төгрөг зарцуулсан нь зарцуулбал зохих хөрөнгийн 9,2%-тай тэнцэж байна. Үлдэх 90,8% буюу 122,5 сая төгрөгийг төсвийн бусад зардалд зарцуулжээ.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.4-тэй нийцэж байна.

Эдгээрээс агнуурын бүсэд мониторингийн судалгаа хийх, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг хийсэн байна.

Дадал Биндэр Өмнөдэлгэр Цэнхэрмандал, Хэрлэн сумдад 3,6 сая төгрөгийн мониторингийн судалгааг сумдын ажилтнуудаар хийлгэсэн байна.

Мөн Дадал, Батширээт, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Биндэр, Дархан, Дэлгэрхаан сумдад 8,8 сая төгрөгийн өвс, хужир, шүү, лаг зэргийн зэрлэг амьтдад тавьж өгсөн байна.

Харин тус ургамал, ан, амьтны нөөц ашигласны нөхөн сэргээлтийн зардлаас үр дүн багатай, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заагдаагүй ажилд төсвийн тодотголд өөрчлөлт хийх замаар нэмэгдүүлэн баталж хэрэгжүүлсэн боловч санхүүжилтийг он дамжуулан олгохоор шийдвэрлэсэн байна.

Хэрлэн голын эрэгт загас үржүүлгийн талбайн хашаа барих нэрээр 22,0 сая төгрөг, батлан 2016 онд хэрэгжүүлсэн байна.

3.5 Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлсэн байна.

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас элбэг ургамлын ахуйн хэрэгцээнд ашигласан, хадлан бэлтгэл, ахуйн хэрэглээний болон түймэр унтраах, газар тариалангийн болон үйлдвэрлэлийн технологид эргүүлэн ашигласан усны төлбөр зэргийг тооцоогүй байна.

Харин байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тусгагдсан ажил ан амьтан нутагшуулах зорилгоор барьж шилжүүлэн нутагшуулсан амьтныг байгалын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлсөн байна.

Норовлин сумын нутаг дахь “Могойтын ам”-нд 30 толгой Монгол тарвагыг сэргээн нутагшуулах ажлын хүрээнд шилжүүлсэн байна.

Эрдэм шинжилгээний зориулалтаар түр барьсан загас, ажиглалт хийсэн ажилд мөн төлбөр хураамжийг ногдуулалгүй, чөлөөлсөн байна.

Хэрлэн голын дагуу 10 цэгт загасны шилжилт хөдөлгөөн, тархацын ажиглалт, мониторинг судалгаа хийсэн байна.

Бусад чиглэлээр хийгдсэн ажлын талаар

2015 онд Хэнтий аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд ой, ус, ан, амьтны чиглэлээс гадна газрын чиглэлээр 3 төсөл, арга хэмжээнд 30,5 сая төгрөг, бусад 8 төсөл, арга хэмжээнд 32,1 сая төгрөг зарцуулсан байна.

2015 онд нийтдээ байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгдсөн 48 төсөл, арга хэмжээнээс 67,5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ санхүүжилт хүрэлцээгүйн улмаас 2016 онд санхүүжилтийг олгохоор хойшлуулсан бол үлдсэн 44 төсөл арга хэмжээний 235,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Эдгээр 2016 онд санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн ажлууд нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор санхүүжүүлэх төсөл арга хэмжээнд хамаарахгүй ажлууд орсон байна.

Хэрлэн голын эрэгт загас үржүүлгийн хашаа барих, Чингис хотын нийтийн хог цэвэрлэгээний машин худалдан авах, Чингис хотын нийтийн хог цэвэрлэгээ, хог дарж булах ажлын шатахуун зэрэг ажлууд орсон байна.

/сая.төг/

№	ТАХ-ний чиглэл	Бүрэн санхүүжсэн ТАХ		Үүнээс:	Он дамжсан ТАХ		Нийт ТАХ	
		тоо	дүн	Дутуу санхүүжсэн дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Амьтны чиглэлээр	13	12,4	-	1	22,0	14	34,4
2	Ойн нөөцийг хамгаалах чиглэлээр	10	75,9	0,5	-	-	10	76,4
3	ТХГ-т зарцуулсан	2	15,5	-	-	-	2	15,5
4	Ус, рашааны чиглэлээр	12	84,5	17,0	1	18,0	13	119,5
5	Газрыг нөхөн сэргээх чиглэлээр	1	15,0	-	-	-	1	15,0
6	Бусад ТАХ-нд	6	32,1	9,1	2	27,5	8	68,7
	Нийт	44	235,4	26,6	4	67,5	48	329,5

2015 онд байгалийн нөөц ашигласны орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний хүрээнд бэлчээрийн даацын судалгаа хийх, газрын нөхөн сэргээлт зэрэг арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн байна.

Байгаль орчны болон ойн салбарын уулзалтад 6,6 сая төгрөг, байгаль хамгаалагч нарыг өвөл, зуны хувцастай болгоход 17,7 сая төгрөг зарцуулсан байна.

Мөн Байгаль орчны салбарын болон ойн салбарынхны уулзалт, сургалт сурталчилгааны ажил нийтийн болон хог цэвэрлэгээний зардал, хогны автомашин худалдан авах зэрэг төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн байна.

Норовлин сумын Тосон хулстай БНГ-т 10 аг талбайг нөхөн сэргээхэд 15,0 сая төгрөг зарцуулсан байна.

2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 203,3 сая төгрөг буюу зарцуулбал зохих зардлын 39,3%-ийг зарцуулж 314,1 сая төгрөг буюу 60,7%-ийг төсвийн бусад зардалд зарцуулсан байна.

2015 оны Байгалийн НАТО-ын гүйцэтгэлээс БХНС3-д хуулийн дагуу зарцуулсан байдал

д/д	Орлогын төрөл	Байгалын НАТО	БХНС3-д зарцуулбал зохих	БХНС3-д хуулийн дагуу зарцуулсан	Зориулалт бусаар зарцуулсан
1	Ойн НАТО	252,6	214,7	75,9	-138,8
2	Ус, рашааны НАТО	408,1	142,8	84,5	-58,3
3	Амьтны НАТО	269,8	134,9	12,4	-122,5
4	Газрын төлбөр	166,3	24,9	30,5	+5,6
	ДҮН	1096,3	517,4	203,3	314,1

**ДӨРӨВДҮГЭЭР
БҮЛЭГ**

**•БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЗАРДАЛ ДУТМАГ БАЙНА.**

4.1 Байгаль орчныг хамгаалах хууль эрх зүйн тогтолцоо бүрдсэн байна.

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.4-д сумын байгаль хамгаалагчийг томилж чөлөөлөх асуудлыг тухайн сумын Засаг дарга шийдвэрлэхээр заасан боловч Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-76 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын үлгэрчилсэн дүрэм”-ийн газрын даргын эрх, үүргийн 2.2.29-д “Сум дүүрэгт ажиллах байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу томилж, чөлөөлөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана” гэж заасан нь хуулийн дээрх заалттай нийцээгүй байна.

орон нутагт “Төсвийн тухай” хуулийн хүрээнд асуудлыг шийдэрлэж байгаа нь хууль хоорондын зөрчилтэй асуудлыг үүсгэж байна.

Сумын ЗДТГ-ын орон тоонд байгаль хамгаалагчийн орон тоо, цалингийн санг батлаагүй боловч “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 26.4.4⁸-т байгаль хамгаалагчийг сумын Засаг дарга томилохоор заасан, нөгөө талаас аймгийн БОАЖГ-ын бүтцэд байгаль хамгаалагчийн орон тоо, цалингийн санг баталсан зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Хэнтий аймагт өнөөдрийн байдлаар аймгийн БОАЖГ-ын дарга нь “Төсвийн тухай” хуулийн 16.5.3⁹ дах заалтыг үндэслэн байгаль хамгаалагчийг томилж чөлөөлснийг хууль зөрчсөн үйлдэл, “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн хүрээнд шийдвэрлэх ёстой хэмээн шүүхэд гомдол гарган шат шатны шүүхээс байгаль хамгаалагчдыг томилж чөлөөлөх ажлыг “Байгаль орчныг хамгаалах тухай” хуульд зааснаар томилж, чөлөөлөх ёстой гэж шүүхийн шийдвэр гарчээ.

Өмнөдэлгэр сумын байгаль хамгаалагч С.Шижирбаатар нь “Төсвийн тухай” хуулиар бус “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийг мөрдөж байгаль хамгаалагч томилогдож, чөлөөлөгдөх ёстой хэмээн ТАЗ болон анхан болон давж заалдах шатны шүүхэд хандан шийдвэрлүүлэн сумын Засаг даргын Захирамжаар томилогдсон бол бусад 17 сумын байгаль хамгаалагчийг аймгийн БОАЖГ-ын даргын тушаалаар томилогдсон байна.

Энэхүү асуудал нь зөвхөн Хэнтий аймагт бус улсын хэмжээнд шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болохоор байна.

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулинд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тооцох талаархи болон байгаль хамгаалагч нарын ажиллах орчныг хамгаалсан эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн нь энэ чиглэлээр эрх зүйн зохицуулалт байна гэж үзэж байна.

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас 2015 онд байгаль орчны хуулийн хэрэгжилтэд хийх хяналт шалгалт болон сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөгөөнд тусгасны дагуу санхүүжүүлсэн байна.

⁸ Байгаль хамгаалагчийг энэ хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан нормативын дагуу сум, дүүргийн улсын байцаагчийн саналыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга томилж чөлөөлнө

⁹ Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;

Шонхорын хяналт шалгалтаар Хэрлэн, Жаргалтхаан, Биндэр, Өлзийт, Тахилгат сум тосгонд 5 байгаль хамгаалагч ажиллахад 3.3 сая төг, Батноров суманд өнгөт чулууны хяналтаар шатахууны зардалд 0.5 сая төг, Хэрлэн суманд Хэрлэн гол дагуу загас агнуурын хяналтаар 0.5 сая төг, Өлзийт, Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Тахилгат, Баянхутаг, Баян-Овоо, Баянмөнх сумдад байгаль орчныг хамгаалах хөдөлгөөнт эргүүл ажиллуулахад 0.4 сая.төг зарцуулсан.

Хэдийгээр хуульд тодорхой зохицуулалтыг хийж өгсөн боловч байгаль хамгаалах чиглэлээр байгаль хамгаалагч нарыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах техник хангалт, бие хамгаалах хэрэгсэл, урсгал зардлыг тусгаж батлахгүй байгаа нь сумдын Засаг дарга нар Байгаль хамгаалах хуульд заасан үүргээ бүрэн биелүүлэхгүй байгааг харуулж байна.

Мөн Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “в”¹⁰-г хүчингүй болгосон байтал 17 сумдын байгаль хамгаалах сан татан буугдалгүй өнөөдрийг хүртэл ашиглагдсаар байна.

Баян-Адарга сумын Байгаль хамгаалах сан 2015 оны санхүүгийн жилээр дуусгавар болон хаагдсан байна.

Зарим суманд төрийн санд данс нээх боломжгүй тул арилжааны банкинд данс нээн байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлсэн байна.

Хэрлэн сум нь байгаль хамгаалах сангийн данс төрийн санд байхгүй байхад “Хаан” банкинд данс нээж нөхөн сэргээлтийн барьцаанд 2015 онд 1.2 сая төгрөг, 2016 оны 7 сар хүртэл 2.8 сая төгрөг төвлөрүүлж, 2.7 сая төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан байна.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор “Ан, амьтны экологи, эдийн засгийн үнэлгээ”-г тогтоохдоо нян хатан бус, бодит байдлаас хэт өндрөөр тогтоосон нь агнуурын орлогын төлөвлөгөө тасрах, хууль бусаар агнуур явагдах үндэс болж байна.

Тус тогтоолын Хавсралтын 1.8-д заасан “Цагаан зээр”¹¹-ийн үнэлгээг үндэслэн аймгийн ИТХ-ын 2014 оны 05 дугаар тогтоолоор цагаан зээрийн төлбөр болон хураамжийг¹² тухайн үнэлгээний хамгийн доод хувиар тооцоход өнөөдөр зах зээл дээр худалдаж байгаа малаас өнөөдөр үнэтэй байгаа тул иргэд зөвшөөрлийг худалдаж авахгүй хууль бусаар агналт явуулах эрсдэлтэй байна.

Учир нь намрын улирал Хэнтий аймгийн нутагт 130, орчим мянган толгой цагаан зээр орж ирдэг тул агнуурын боломжит толгойг 350 гэж тогтоосон боловч төлөвлөгөөгөөр 100-110 толгойг агнуулахаар төлөвлөдөг боловч орлого тасардаг байна.

2016 оны 9 сарын байдлаар хонь 50,0-70,0 мян.төг байхад цагаан зээр-110,0 мян.төг байгаа нь бодит ханшийг илтгэж чадахгүй байна.

Иймд энэхүү тогтоолыг эргэн харж зарим ан агнуурын үнэлгээг тухайн цаг үед тааруулж уян хатан болгон өөрчилж байх шаардлагатай байна.

4.2 Байгаль орчны тухай хуулийн хэрэгжилтэд хийгдэх хяналт шалгалтанд зардал дутмаг байна.

¹⁰ в/орон нутгийн төсвийн бус орлогоор хөгжлийн сан байгуулах, уг сангийн эх үүсвэр, зориулалтыг тогтоох, сангийн хөрөнгийн зарцуулалтын журам, тайланг батлах

¹¹ Цагаан зээр: эр-500,0 мян.төг, эм-550,0 мян.төг,

¹² Цагаан зээр: хураамж-100,0 мян.төг, эрхийн бичиг-10,0 мян.төг,

Сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах тээврийн хэрэгсэл, түүний шатахуун, харилцаа холбооны хэрэгсэл, албаны дүрэмт хувцас, бие хамгаалах хэрэгсэл зэргийн хангалт сумдад хангалтгүй байна.

Сумдын байгаль хамгаалагч нарыг өвөл, зуны дүрэмт хувцасаар бүрэн хангасан бол бие хамгаалах хэрэгсэл, унаа, урсгал зардлыг шийдвэрлэж чадахгүй байгаа нь тухайн ажилтнууд албан үүргээ гүйцэтгэхэд хүндрэл үүсгэж байна.

2015 онд байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас байгаль хамгаалагчдын өвлийн хувцасны зардал 17,7 сая төгрөгийг санхүүжүүлж чанарын шаардлага хангахгүй хувцас нийлүүлсэн учир үлдэгдэл санхүүжилтийг хассан байна.

“Мянган мөөжгий” ХХК нь чанарын шаардлага хангаагүй байгаль хамгаалагчдын зуны хувцасны 4,3 сая төг, гуталны 3,2 сая төг-ийн үлдэгдэл санхүүжилтийг тус тус олгоогүй байна.

Мөн өнөөдрийн байдлаар сумдад ажиллаж байгаа байгаль орчны улсын байцаагчдын бие хамгаалах хэрэгсэл болон техник хэрэгслийн хангалт хангалтгүй байгаа нь тэднийг ажил үүргээ гүйцэтгэх хүндрэлийг үүсгэж байна.

Байгаль хамгаалагч нарын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах урсгал зардлыг төсөвт тусган батлуулж чадаагүй тул байгаль орчныг хамгаалах талаархи хуулийн хүрээнд эргүүл, шалгалтын үед шаардагдах шатахууны зардлыг байгаль хамгаалах санд төвлөрсөн орлогоос шууд гарган зарцуулж байна.

Цэнхэрмандал сум БХС-аас шатахууны зардалд 5.4 сая төгрөг, 0.2 сая төгрөгийн принтерийн хор, Биндэр сум БХС-аас 0.4 сая төгрөгөөр автомашины сэлбэг зэрэг зарцуулсан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлгүй төлөвлөж байгаагаас орлого дутуу бүрдэх нөхцөл үүсч байна.
- Байгалийн нөөц ашигласны орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулах хөрөнгийг үндэслэлгүйгээр бууруулан баталж байна.
- Батлагдсан төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх, зориулалт бусаар зарцуулах зөрчил гарч байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга Л.Батсайхан-д

- Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд зарцуулах хөрөнгийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалтыг мөрдөн баталж байх,

Аймгийн Засаг дарга Н.Ганбямба-д

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалтыг мөрдөн тооцож батлуулж байх,

Аймгийн БОАЖГ-ын дарга Г.Энхбаяр-т

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн гүйцэтгэн дуусгаж байх,
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зориулагдсан хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх,

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ТАВИХ САНАЛ

1. БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-76 тоот тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.2.29-д заасан байгаль хамгаалагч нарыг томилох, чөлөөлөх тухай заалтыг хасах
2. Сумын ЗДТГ-т байгаль хамгаалагчийн орон тоог нэмэх асуудлыг Засгийн газарт тавих,
3. Аймгийн БОАЖГ-ын төсөвт тусгагдсан байгаль хамгаалагчийн цалингийн зардлыг сумын ЗДТГ-ын төсөвт шилжүүлэх
4. Сумын байгаль хамгаалагчийн хувцас, хэрэглэлийг аймгийн БОАЖГ нэгдсэн журмаар бэлтгэх нь төсөвт хэмнэлттэй тул дүрэмд хэвээр үлдээх,

Аудитын тайланд дурьдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээ, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2016 оны 10-р сарын 30-ны дотор албан бичгээр, хийгдсэн ажил, үр дүнгийн талаарх мэдээллийг 2016 оны 12 сарын 20-ны дотор гаргаж албан бичгээр ирүүлэхийг мэдэгдье.

ТАЙЛАН БИЧСЭН:Шинжээч

Д.Эрдэнэбилэг

2016 оны 10 дугаар сарын 10

Хавсралт №1

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Холбогдох байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн санал	Тайлбар
 АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХЭНТИЙ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР 23115 Чангас хот, Хэнтий аймаг Утас/факс: 70-56-24-12 E-mail: Khentiaudit@yahoo.com 2016.10.11 № 5/1232 татай _____ -ны № _____ Асуудлын бүртгэлийн хариу 1.1 Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 2.13 дэх заалтын дагуу аймаг нь байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй, сум нь тус хуулийн 58 дугаар зүйлийн 4.6 дэх заалтын дагуу сумын нутаг дэвсгэр дэх байгаль орчныг хамгаалах чиг үүргийг тус тус хэрэгжүүлэх үүрэгтэй гэж заасны дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг байгаль орчны газрын төсөвт хөтөлбөр, арга хэмжээ болгон баталдаг. 1.2 Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар бүх сумын 35 байгаль хамгаалагчдыг өвөл, зуны дүрэмт хувцсаар хангахад зориулж 13,7 сая төгрөгийг зарцуулсанаас гадна Дадал, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар нь байгаль хамгаалагч нараа унаагаар хангасан байна. 2.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг оны эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн Байгаль орчны газраас гаргасан тооцооллын дагуу 454,7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн. Гэвч Засгийн газрын 307 дугаар тогтоолоор гоожингийн үнэ нэмэгдэж, иргэдийн худалдан авах чадвар буурсанаас мод бэлтгэдэг мэргэжлийн байгууллагууд төлөвлөсөн хуваарьт модоо бэлтгэж чадаагүйгээс ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 46,6 сая төгрөгөөр, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурсан нь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн хэвийн үйл ажиллагаа алдагдахад нөлөөлж, тус үйлдвэрээс орох усны төлбөрийн орлого 230,7 сая төгрөгөөр тасарсан байна. 3.1 Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг Сангийн яамнаас тооцохдоо байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалтыг мөрдсөнөөс гадна байгаль орчны газраас байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн ажлын тайлан, хэрэгжилт, жилийн эцсийн даясны зарцуулагдаагүй үлдэгдэл зэргийг харгалзан 2015 оны зардлыг 329,6 сая төгрөгөөр хянасан. Өмнөх оноос дараа он руу шилжсэн байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хийгдсэн ажлын гүйцэтгэл 42,6 сая төгрөгийг 2015 онд нэмж тусган санхүүжүүлсэн.  САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.ХЭРЛЭНЧИМЭГ 03 070	1 Суманд төвлөрсөн НАТО-оос аймгийн ИТХ-р баталсан нь байгаль орчны тухай хуулийг мөрдөхгүй байх талаар тусгаагүй тул тайлбарыг хүлээн авах боломжгүй. 2 Дадал, Хэрлэн сумдын байгаль хамгаалагчдыг унаагаар хангасан мэдээллийг тайланд орууллаа. 3 Орлого тасарсныг тайлбарласан тул тайланд өөрчлөлт ороогүй. 4 Аймгийн ИТХ, ЗДТГ нь хууль мөрдөөгүй талаар тайлбар ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт ороогүй.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2016 оны 10 сарын 14 өдөр Дугаар 33 Өндөрхон

Нийцлийн аудитын тайланг
батлах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалаар баталсан "Нийслэл болон аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5, Гүйцэтгэлийн аудитын журам-ын 12.40, Чанарын хяналтын журам-ын 5.3.4, аймгийн Аудитын газрын удирдах зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
3. Аудитын ажлыг үнэлж дүгнэн, үр өгөөжийг тооцож, хариуцлага тооцох саналын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭНХТҮВШИН